



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/77/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 70584204 Цахим
хаяг: Tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Ж.Баяртуул
Утас: 70584207 Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	112
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	113
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	134
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	145
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ
Н.ХҮРЭЛБААТАР ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.18 № 80

танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

2020.02.18 №80

D: Mv computer – TOOT A4

110520005



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Н.Хүрэлбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн хандиваар ирсэн хөрөнгийг баримтжуулах талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-нөөс 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан чадварлаг боловсон хүчийг бэлтгэх”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 29 эрсдэлтэй асуудлыг төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 975,513.0 мянган төгрөгөөс тооцон 19,510.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 24,145.5 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154,284.3 мянган төгрөгөөр буюу 0.98 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	10,196.9	5,002.9	-5,194.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	306,879.6	329,663.3	22,783.7
Үндсэн хөрөнгө	6,295,439.5	6,142,951.4	152,488.1
Элэгдлийн зардал	-211,219.4	230,605.4	-19,385.9
Нийт хөрөнгө	6,401,296.6	6,247,012.3	-154,284.3
Өр төлбөр	20,768.2	4,828.9	-15,939.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,380,528.3	6,242,183.3	-138,345.0
Хуримтлагдсан үр дүн	5,239,676.1	5,101,331.1	-138,345.0
Өмнөх үеийн үр дүн	-	5,101,331.1	-
Тайлангийн үеийн үр дүн	-	-138,345.0	-138,345.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405,206.9	405,206.9	-
Төрийн өмчийн оролцоо	735,645.3	735,645.3	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,401,296.5	6247,012.2	-154,284.3

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь малын нас дэвшлийн орлого болон бусад хангамжийн материалын орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант жилд хөрөнгө актлагдсанаас шалтгаалсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,242,183.3 мянган төгрөг болж -138,345.0 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал өндөр дүнтэй байгаагаас шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тайлант онд туслах үйл ажиллагааны орлого 8'000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2,126.0 мянган төгрөгөөр буюу 26,6 хувиар тасарсан байна.

Хүснэгт 2: Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Туслах үйл ажиллагаа	8,000.0	5,569.9	-2,126.0	26,6
	Нийт дүн	8,000.0	5,569.9	-2,126.0	26,6

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 955,530.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд төлөвлөгдсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 953,059.6 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант жилд “Угтамын хийд” засварын 9,700.0 мянган төгрөгийн засварт, өмнөх оны авлага барагдуулсан 5,194.0 мянган төгрөгийн оюутнуудад өгөх өглөгийг барагдуулж тус тус зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 29 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 51,032.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 12,451.2 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 33,161.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5,420.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1. Тайлант хугацаанд хийсэн 30,506.8 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”*, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Онд дамжсан авлагын үлдэгдэл 528,4 мянган төгрөгийг барагдуулах арга хэмжээ зохион байгуулаагүй нь *Төсвийн тухай хуулийн 6.4.8. дахь*

"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Тайлант жилд туслах үйл ажиллагаа орлого 8,000.0 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн боловч 2,126.0 мянган төгрөгөөр орлого тасарсан нь *Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн 5,420.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийн ашиглалт

1.1. Илрүүлэлт: Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан тушаалын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад 5,420.0 мянган төгрөгийн шатахууныг тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	317 076 519,37	334 666 196,37
33	АВЛАГА	10 196 892,00	5 002 932,00
335	Бусад авлага	10 196 892,00	5 002 932,00
3351	Байгууллагаас авах авлага	9 762 392,00	4 568 432,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	434 500,00	434 500,00
35	БАРАА МАТЕРИАЛ	306 879 627,37	329 663 264,37
351	Түүхий эд материал	178 943 046,80	178 993 233,80
35110	Тусгай зориулалттай материал	178 943 046,80	178 993 233,80
354	Хангамжийн материал	73 406 580,57	91 610 030,57
35410	Бичиг хэргийн материал	1 026 421,00	818 000,00
35420	Аж ахуйн материал	56 364 132,00	78 129 153,00
35430	Сэлбэг хэрэгсэл	4 121 450,00	3 801 450,00
35450	Барилгын засварын материал	6 388 477,57	5 871 927,57
35460	Хүнсний материал	5 506 100,00	2 989 500,00
35600	Мал амьтад	54 530 000,00	59 060 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6 084 220 107,98	5 912 346 089,72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6 084 220 107,98	5 912 346 089,72
392	Биет хөрөнгө	5 778 653 232,98	5 606 936 714,72
39201	Барилга, байгууламж, орон сууц	4 587 163 687,00	4 587 163 687,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-104 225 028,42	-188 642 056,02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73 516 000,00	73 516 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-57 541 833,04	-62 028 499,60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	786 604 779,00	814 999 029,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-550 089 580,75	-644 792 469,33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139 247 730,00	138 575 615,59
39208	Хуримтлагдсан элэгдэл	-83 314 273,81	-99 146 344,92
39214	Бусад үндсэн хөрөнгө	949 818 176,00	949 818 176,00
39217	Ном	37 473 577,00	37 473 577,00
393	Биет бус хөрөнгө	305 566 875,00	305 409 375,00
39301	Програм хангамж	17 955 000,00	17 955 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-17 763 125,00	-17 920 625,00
39303	Бусад биет бус хөрөнгө	305 375 000,00	305 375 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6 401 296 627,35	6 247 012 286,09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20 768 207,90	4 828 875,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20 768 207,90	4 828 875,00
413	Өглөг	20 768 207,90	4 828 875,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7 335 237,90	00,00
4136	Бусад өглөг	13 432 970,00	4 828 875,00
41361	Байгууллагад төлөх өглөг	120 000,00	00,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	13 312 970,00	4 828 875,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6 380 528 419,45	6 242 183 411,10
51	Засгийн газрын хувь оролцоо	6 380 528 419,45	6 242 183 411,10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	735 645 332,00	735 645 332,00
51101	Өмч: - төрийн	735 645 332,00	735 645 332,00
512	Хуримтлагдсан үр дүн	5 239 676 120,45	5 101 331 112,10
51210	Өмнөх үеийн үр дүн	5 239 676 120,45	5 239 676 120,45
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	-138 345 008,36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405 206 967,00	405 206 967,00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6 401 296 627,35	6 247 012 286,09

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	791 388 608,00	1 068 927 126,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83 087 681,00	106 353 945,00
120	Нийтлэг татварын бус орлого	83 087 681,00	106 353 945,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83 087 681,00	82 587 950,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9 356 921,00	7 313 500,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73 730 760,00	75 274 450,00
120009	Бусад орлого	00,00	23 765 995,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	708 300 927,00	962 573 181,00
1310	Удсын төвлөрсөн төсвөөс	674 625 800,00	944 559 600,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	674 625 800,00	944 559 600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33 675 127,00	8 281 436,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2 048 000,00	2 880 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31 627 127,00	5 401 436,00
1330	Төсвийн захирагчдаас	00,00	9 732 145,00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00,00	9 732 145,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	975 513 006,82	1 207 272 134,36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	975 513 006,82	1 207 272 134,36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	924 545 004,02	1 076 889 270,36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429 839 382,89	553 331 591,47
210101	Үндсэн цалин	427 315 615,06	552 078 126,47
210102	Нэмэгдэл	00,00	95 029,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2 523 767,83	00,00
210104	Урамшуулал	00,00	496 000,00
210105	Гэрээт ажлын хөлс	00,00	662 436,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51 068 976,21	69 080 533,63
210201	Тэтгэврийн даатгал	34 084 107,45	47 059 242,87
210202	Тэтгэмжийн даатгал	4 260 513,45	5 505 322,69
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 408 410,76	4 404 258,15
210204	Ажилгүйдлийн даатгал	846 904,05	1 101 064,54
210205	Эрүүл мэндийн даатгал	8 469 040,50	11 010 645,38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62 874 910,00	73 737 880,00
210301	Гэрэл, цахилгаан	13 874 755,00	18 507 762,00
210302	Түлш, халаалт	41 656 704,00	45 635 101,00
210303	Цэвэр, бохир ус	7 343 451,00	9 595 017,00
2104	Хангамж, бараа материалын зардал	10 579 851,00	14 429 329,00
210401	Бичиг хэрэг	2 942 721,00	2 942 295,00
210402	Тээвэр, шатахуун	4 429 640,00	6 207 548,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 705 990,00	4 520 266,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	501 500,00	739 700,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00,00	19 520,00
2105	Нормативт зардал	33 981 376,00	30 980 229,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00,00	297 000,00
210502	Хоол, хунс	33 981 376,00	30 683 229,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 089 700,00	3 191 500,00
210604	Урсгал засвар	1 089 700,00	3 191 500,00
2107	Томилголт, зочны зардал	5 049 000,00	5 049 000,00
210702	Дотоод албан томилголт	5 049 000,00	5 049 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4 796 100,00	2 811 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	2 774 230,00	280 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800 000,00	800 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	846 400,00	998 200,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300 000,00	207 900,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	75 470,00	524 900,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	325 265 707,92	324 278 207,26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6 310 000,00	6 090 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	107 736 344,98	87 582 939,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	211 219 362,94	230 605 268,26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50 968 002,80	130 382 864,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17 348 580,00	88 412 802,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4 986 000,00	49 053 900,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	11 172 580,00	37 055 652,00
2133	Удсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33 619 422,80	41 970 062,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33 619 422,80	41 970 062,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-184 124 398,82	-138 345 008,36
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3 540 000,00	00,00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	3 540 000,00	00,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	3 540 000,00	00,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-180 584 398,82	-138 345 008,36

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	723 158 538,00	997 500 836,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9 223 876,00	29 639 795,00
120	Нийтлэг татварын бус орлого	9 223 876,00	29 639 795,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9 223 876,00	5 873 800,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9 223 876,00	5 873 800,00
120009	Бусад орлого	00,00	23 765 995,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	713 934 662,00	967 861 041,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	674 625 800,00	944 559 600,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	674 625 800,00	944 559 600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39 308 862,00	13 569 296,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2 048 000,00	2 880 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37 260 862,00	10 689 296,00
1330	Төсвийн захирагчдаас	00,00	9 732 145,00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00,00	9 732 145,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	723 158 538,00	991 930 936,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723 158 538,00	991 930 936,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672 706 535,20	860 548 072,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	421 885 908,00	562 661 123,00
210101	Үндсэн цалин	331 550 750,00	411 213 256,00
210102	Нэмэгдэл	61 103 442,00	98 435 455,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29 231 716,00	17 671 152,00
210104	Урамшуулал	00,00	34 241 260,00
210105	Гэрээт ажлын хөлс	00,00	1 100 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51 698 200,00	67 643 804,00
210201	Тэтгэврийн даатгал	34 465 400,00	47 049 462,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 308 200,00	5 900 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 446 500,00	4 720 400,00
210204	Ажилгүйдлийн даатгал	861 700,00	1 180 100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8 616 400,00	8 793 342,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63 371 260,00	74 691 880,00
210301	Гэрэл, цахилгаан	13 874 755,00	18 507 762,00
210302	Түлш, халаалт	41 656 704,00	45 635 101,00
210303	Цэвэр, бохир ус	7 839 801,00	10 549 017,00
2104	Хангамж, бараа материалын зардал	15 288 240,00	14 883 514,00
210401	Бичиг хэрэг	2 931 480,00	2 943 848,00
210402	Тээвэр, шатахуун	6 666 730,00	6 207 500,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 660 990,00	4 368 766,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	501 500,00	739 700,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 527 540,00	623 700,00
2105	Нормативт зардал	28 828 117,80	34 089 351,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	363 000,00	297 000,00
210502	Хоол, хүнс	26 665 117,80	23 604 351,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 800 000,00	10 188 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6 295 141,00	8 688 360,00
210604	Урсгал засвар	6 295 141,00	8 688 360,00
2107	Томилголт, зочны зардал	5 049 000,00	5 049 000,00
210702	Дотоод албан томилголт	5 049 000,00	5 049 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4 389 430,00	3 132 500,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 444 830,00	280 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800 000,00	800 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	846 400,00	998 200,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300 000,00	207 900,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	998 200,00	846 400,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75 901 238,40	89 708 540,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75 901 238,40	89 708 540,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50 452 002,80	131 382 864,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16 832 580,00	89 412 802,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4 986 000,00	49 053 900,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11 172 580,00	37 055 652,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	674 000,00	3 303 250,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33 619 422,80	41 970 062,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33 619 422,80	41 970 062,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00,00	5 569 900,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00,00	5 569 900,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00,00	5 569 900,00
2200	Дотоод эх үүсвэрээр	00,00	5 569 900,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00,00	5 569 900,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00,00	-5 569 900,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430 270 332,00	593 546 900,00	4 444 137 705,55	00,00	5 467 954 937,55
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430 270 332,00	593 546 900,00	4 444 137 705,55	00,00	5 467 954 937,55
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	540 210 656,78	00,00	540 210 656,78
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735 645 332,00	405 206 967,00	5 239 676 120,45	00,00	6 380 528 419,45
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735 645 332,00	405 206 967,00	5 239 676 120,45	00,00	6 380 528 419,45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735 645 332,00	405 206 967,00	5 239 676 120,45	00,00	6 380 528 419,45
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-138 345 008,36	00,00	-138 345 008,35
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735 645 332,00	405 206 967,00	5 101 331 112,10	00,00	6 242 183 411,10

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 005 837 600,00	908 810 974,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 005 837 600,00	908 810 974,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	884 308 600,00	820 248 172,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590 053 600,00	561 561 123,00
210101	Үндсэн цалин	417 445 500,00	411 213 256,00
210102	Нэмэгдэл	103 525 600,00	98 435 455,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30 888 000,00	17 671 152,00
210104	Урамшуулал	38 194 500,00	34 241 260,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73 756 700,00	67 379 804,00
210201	Тэтгэврийн даатгал	50 154 600,00	46 785 462,00
210202	Тэтгэмжийн даатгал	5 900 500,00	5 900 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4 720 400,00	4 720 400,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 180 100,00	1 180 100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	11 801 100,00	8 793 342,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83 846 100,00	74 691 880,00
210301	Гэрэл, цахилгаан	18 523 000,00	18 507 762,00
210302	Түлш, халаалт	48 321 000,00	45 635 101,00
210303	Цэвэр, бохир ус	17 002 100,00	10 549 017,00
2104	Хангамж, бараа материалын зардал	12 860 000,00	12 683 314,00
210401	Бичиг хэрэг	2 945 200,00	2 943 848,00
210402	Тээвэр, шатахуун	4 207 500,00	4 207 500,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 544 100,00	4 368 766,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	539 500,00	539 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	623 700,00	623 700,00
2105	Нормативт зардал	53 949 500,00	34 089 351,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	297 000,00	297 000,00
210502	Хоол, хүнс	43 464 500,00	23 604 351,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10 188 000,00	10 188 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7 752 200,00	7 752 200,00
210604	Урсгал засвар	7 752 200,00	7 752 200,00
2107	Томилолт, зочны зардал	5 049 000,00	5 049 000,00
210702	Дотоод албан томилолт	5 049 000,00	5 049 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2 852 500,00	2 852 500,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800 000,00	800 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	998 200,00	998 200,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207 900,00	207 900,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	846 400,00	846 400,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54 189 000,00	54 189 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54 189 000,00	54 189 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121 529 000,00	88 562 802,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	121 529 000,00	88 562 802,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62 061 900,00	49 053 900,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	55 717 100,00	37 055 652,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3 750 000,00	2 453 250,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	953 059 600,00	908 810 974,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	944 559 600,00	903 409 538,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	944 559 600,00	903 409 538,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8 500 000,00	00,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8 500 000,00	00,00

